

**10 дугаар бүлэгт дурдсан  
8 дугаар хавсралт**

**10.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан  
одоо мөрдөж буй арга хэмжээнүүд**

(1 дэх хэсэг нь япон, англи хэлээр байх ба  
энэхүү хавсралтын салшгүй хэсэг болно)

**2 дахь хэсэг  
МОНГОЛ УЛСЫН ЖАГСААЛТ**

1. Монгол Улсын жагсаалтад 10.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу монголын талаас одоо мөрдөж буй бөгөөд доорх зүйлд заасан үүрэгтэй үл нийцэх хадгалах нөхцөлтэй арга хэмжээг тусгав:

- (a) 10.3 дугаар зүйл;
- (b) 10.4 дугаар зүйл;
- (c) 10.7 дугаар зүйл.

2. Хадгалах нөхцөл бүр дараахь бүрэлдэхүүн хэсгийг агуулна:

- (a) “Салбар” гэх нэр томьёо нь тухайн хадгалах нөхцөл хамаарах ерөнхий салбарыг хэлнэ;
- (b) “Дэд салбар” гэх нэр томьёо нь тухайн хадгалах нөхцөл хамаарах тодорхой салбарыг хэлнэ;
- (c) “Хадгалах нөхцөлийн төрөл” гэх нэр томьёо нь 1 дэх хэсэгт дурдсан хадгалах нөхцөлд хамаарах үүргийг тодорхойлно.
- (d) “Арга хэмжээ” гэх нэр томьёо нь хадгалах нөхцөлд хамаарах одоо мөрдөж буй хууль тогтоомж, эсхүл бусад арга хэмжээг хэлнэ. “Арга хэмжээ” томьёололд дурдсан арга хэмжээ гэдэг нь:
  - (i) энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдөр нэмэлт, өөрчлөлт орсон, хэрэгжиж байгаа, эсхүл шинэчлэгдсэн арга хэмжээ;

(ii) тухайн арга хэмжээний хүрээнд болон түүнтэй нийцэх байдлаар баталсан буюу үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн аливаа хавсарсан арга хэмжээ.

(e) “Тайлбар” нь 1 дэх хэсэгт дурдсан үүрэгтэй холбоотойгоор хадгалах нөхцөлд хамаарах одоо мөрдөж буй арга хэмжээний үл нийцэх байдлыг тодорхойлно.

3. Хадгалах нөхцөлийн тайлбарт тухайн хадгалах нөхцөлийн бүх бүрэлдэхүүн хэсгийг харгалзан үзнэ. Хадгалах нөхцөлийг түүнийг заасан 10 дугаар бүлгийн холбогдох заалтын хүрээнд тайлбарлана. “Арга хэмжээ” хэсгийг бусад хэсгээс давуу байдлаар авч үзнэ.

|                           |   |
|---------------------------|---|
| 1. Салбар:                | Бүх салбар  |
| Дэд салбар:               |   |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)  |
| Арга хэмжээ:              | <p>2002 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн Газрын тухай хууль, 5, 6 болон 44 дүгээр зүйл</p> <p>2002 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, 28 болон 29 дүгээр зүйл</p> <p>1994 оны 11 дүгээр сарын 15-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 3 дугаар зүйл</p> <p>2004 оны 4 дүгээр сарын 22-ны Тариалангийн тухай хууль, 15 дугаар зүйл</p> |
| Тайлбар:                  | Гадаадын хувь хүн эсхүл хуулийн этгээд Монгол Улсад газар өмчлөхгүй. Гэхдээ тэд газрыг 60 хүртэл жилийн хугацаагаар түрээслэх боломжтой. Түрээслэх тодорхой хугацааг гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу тодорхойлно.   |

|                           |   |
|---------------------------|---|
| 2. Салбар:                | Уул уурхай  |
| Дэд салбар:               |   |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)  |
| Арга хэмжээ:              | 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн Хөрөнгө оруулалтын тухай хууль, 21 болон 22 дугаар зүйл  |
| Тайлбар:                  | Гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгж Монгол Улсын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн нийт хувьцааны 33% буюу түүнээс дээш хувийг эзэмшихээр төлөвлөж байгаа бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай. |

|                           |  |
|---------------------------|--|
| 3. Салбар:                | Санхүү   |
| Дэд салбар:               | Банк болон санхүүгийн бусад үйлчилгээ - Бусад зээл олгох үйлчилгээ болон Санхүүгийн түрээсийн үйлчилгээ  |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)<br>Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)   |
| Арга хэмжээ:              | 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн Банкны тухай хууль, 22 дугаар зүйл<br><br>2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн Хөрөнгө оруулалтын тухай хууль, 21 болон 22 дугаар зүйл  |
| Тайлбар:                  | 1. Гадаадын хөрөнгө оруулагч эсхүл гадаадын банк дээр дурдсан дэд салбарт гүйцэтгэгчээр ажиллах, эсхүл шинэ салбар, төлөөлөгчийн газар нээх тохиолдолд Монгол Банкнаас урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай.<br><br>2. (a) Гадаадын төрийн өмчит компани Монгол Улсын банк санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн нийт хувьцааны 33% буюу түүнээс дээш хувийг эзэмшихээр төлөвлөж байгаа бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай;<br><br>(b) Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан тохиолдолд гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгохдоо холбогдох эрх бүхий байгууллага зөвшөөрлийн нөхцөл болгон 10.7 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны шалгуурыг тавьж болно. |

4. Салбар: Харилцаа холбоо болон өргөн нэвтрүүлэг
- Дэд салбар:
- Хадгалах нөхцөлийн төрөл: Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)  
Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)
- Арга хэмжээ: 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн Хөрөнгө оруулалтын тухай хууль, 21 болон 22 дүгээр зүйл
- Тайлбар:
1. Гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгж Монгол Улсын харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн нийт хувьцааны 33% буюу түүнээс дээш хувийг эзэмшихээр төлөвлөж байгаа бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай.
  2. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйл заасны дагуу гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгохдоо холбогдох эрх бүхий байгууллага 10.7 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны шалгуурыг зөвшөөрөл авах нөхцөл болгон тавьж болно.

|                           |  |
|---------------------------|--|
| 5. Салбар:                | Хэвлэл мэдээлэл  |
| Дэд салбар:               |  |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)<br>Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)   |
| Арга хэмжээ:              | 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн Хөрөнгө оруулалтын тухай хууль, 21 болон 22 дугаар зүйл   |
| Тайлбар:                  | <p>1. Гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгж Монгол Улсын хэвлэл мэдээллийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын нийт хувьцааны 33% буюу түүнээс дээш хувийг эзэмшихээр төлөвлөж байгаа бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай.</p> <p>2. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгохдоо холбогдох эрх бүхий байгууллага 10.7 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны шалгуурыг зөвшөөрөл авах нөхцөл болгон тавьж болно.</p> |

|                           |  |
|---------------------------|--|
| 6. Салбар:                | Санхүү   |
| Дэд салбар:               | Даатгал  |
|                           | Банк бус   |
|                           | Хөрөнгө оруулалтын сан   |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)   |
|                           | Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)   |
| Арга хэмжээ:              | 2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Даатгалын тухай хууль, 14 болон 54 дүгээр зүйл  |
|                           | 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, 43 дугаар зүйл  |
|                           | 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн Хөрөнгө оруулалтын тухай хууль, 21 болон 22 дугаар зүйл   |
| Тайлбар:                  | <p>1. Гадаадын аж ахуйн нэгж Монгол Улсын нутаг дэвсгэрт салбар, төлөөлөгчийн газар болон Монгол Улсын хуулийн этгээдийн хэлбэрээр даатгал болон хөрөнгө оруулалтын сангийн бизнес эрхлэхээр төлөвлөж байгаа бол Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авах шаардлагатай.</p> <p>2. (а) Гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгж Монгол Улсын даатгал, банк бус эсхүл хөрөнгө оруулалтын сангийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн нийт хувьцааны 33% буюу түүнээс дээш хувийг эзэмшихээр төлөвлөж байгаа бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай;</p> |



(b) Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгохдоо холбогдох эрх бүхий байгууллага 10.7 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны шалгуурыг зөвшөөрөл авах нөхцөл болгон тавьж болно.

|                           |  |
|---------------------------|--|
| 7. Салбар:                | Санхүү   |
| Дэд салбар:               | Хадгаламж, зээлийн хоршоо  |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)   |
| Арга хэмжээ:              | 2011 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, 5 дугаар зүйл                                 |
| Тайлбар:                  | Гадаадын хувь хүн болон хуулийн этгээд, эсхүл байгууллага хадгаламж, зээлийн хоршооны салбарт үйл ажиллагаа эрхлэх хориотой. |

|                           |  |
|---------------------------|--|
| 8. Салбар:                | Газрын тос   |
| Дэд салбар:               |  |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)   |
| Арга хэмжээ:              | 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн Газрын тосны тухай хууль, 5, 7 болон 33 дугаар зүйл<br><br>2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, 7 дугаар зүйл  |
| Тайлбар:                  | Монгол Улсын газрын тосны салбарт үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөж байгаа гадаадын хөрөнгө оруулагч холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд 10.7 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны шалгуур тавигдаж болох бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах шаардлагатай.<br><br>Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний нийт импортын 30-аас дээш хувийг эзэмшдэг гадаадын хуулийн этгээд дотоодын түгээлт болон/эсхүл өөрийн борлуулалтыг, өөрийн хөрөнгө оруулсан компани болон/эсхүл өөрийн хянадаг эсхүл оролцооны ашгийн хувьтай аливаа хуулийн этгээдээр дамжуулан хийхийг хориглоно. |

|                           |  |
|---------------------------|--|
| 9. Салбар:                | Бүх салбар   |
| Дэд салбар:               |  |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)   |
| Арга хэмжээ:              | 2001 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, 8 дугаар зүйл             |
| Тайлбар:                  | Холбогдох эрх бүхий байгууллага нь Засгийн газраас жил бүр баталдаг квотын хэмжээг харгалзан гадаадын ажилчдад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоно. |

|                           |  |
|---------------------------|--|
| 10. Салбар:               | Бүх салбар   |
| Дэд салбар:               |  |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)   |
| Арга хэмжээ:              | 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн Хөрөнгө оруулалтын тухай хууль, 3.1.5 дугаар зүйл   |
| Тайлбар:                  | Монгол Улсад хөрөнгө оруулах гадаадын хөрөнгө оруулагч бүрийн хөрөнгө оруулалтын доод босго нь тухайн хуулийн этгээдийн хувьцааны 25 болон түүнээс дээш хувийг эзэмших тохиолдолд 100,000 ам.доллар байна. |

|                           |   |
|---------------------------|---|
| 11. Салбар:               | Бүх салбар  |
| Дэд салбар:               |   |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)  |
| Арга хэмжээ:              | 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 8 дугаар зүйл  |
| Тайлбар:                  | Гадаадын хөрөнгө оруулалттай компаниас бусад зөвхөн Монголын дотоодын аж ахуйн нэгж байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийж болно. |

|                           |   |
|---------------------------|---|
| 12. Салбар:               | Бүх салбар  |
| Дэд салбар:               | Тэсэлгээний үйлдвэрлэл  |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)  |
| Арга хэмжээ:              | 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, 11 дүгээр зүйл   |
| Тайлбар:                  | Монголд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн гадаадын хөрөнгө оруулагчийн хувь эзэмшил нь тухайн хуулийн этгээдийн нийт хувьцааны 49 хувиас бага байна. |

13. Салбар: Ан агнуур
- Дэд салбар:
- Хадгалах нөхцөлийн төрөл: Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)
- Арга хэмжээ: 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 17 дугаар зүйл
- Тайлбар: Зэрлэг ан амьтан агнахад авах төлбөр, хураамж гадаадын иргэний хувьд Монгол Улсын иргэнээс ялгаатай байна.



14. Салбар: Байгалийн ургамал түүх
- Дэд салбар:
- Хадгалах нөхцөлийн төрөл: Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)
- Арга хэмжээ: 1995 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Байгалийн ургамлын тухай хууль, 17 дугаар зүйл
- Тайлбар: Гадаадын иргэн, гадаадын хуулийн этгээд болон гадаадын байгууллага аливаа зориулалтаар байгалийн ургамлыг түүж, хураахыг хориглоно.

|                           |   |
|---------------------------|---|
| 15. Салбар:               | Усны судалгаа   |
| Дэд салбар:               |   |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)  |
| Арга хэмжээ:              | 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн Усны тухай хууль, 5 дугаар зүйл  |
| Тайлбар:                  | Гадаадын иргэн, хуулийн этгээд холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр усны сав газар аливаа ус болон усны холбогдолтой байгаль орчны судалгаа явуулахыг хориглоно. |

16. Салбар: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдаа
- Дэд салбар:
- Хадгалах нөхцөлийн төрөл: Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)
- Арга хэмжээ: 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, 10 дугаар зүйл
- Тайлбар: Гадаадын иргэн болон хуулийн этгээд хөдөө аж ахуйн болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний биржийн худалдаанд зөвхөн биржийн зах зээлийн байнгын гишүүнээр зуучлуулан оролцоно.

|                           |   |
|---------------------------|---|
| 17. Салбар:               | Эрчим хүч   |
| Дэд салбар:               | Цөмийн эрчим хүч  |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)  |
| Арга хэмжээ:              | 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн Цөмийн энергийн тухай хууль, 5 дугаар зүйл   |
| Тайлбар:                  | Монгол Улсын Засгийн газар нь улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийг ашиглах зорилгоор байгуулагдсан компанийн нийт хувьцааны 51-ээс доошгүй хувийг эзэмшинэ. Ийм компанийн хувьцааг эзэмшдэг хөрөнгө оруулагчид 10.7 дугаар зүйлд заасны дагуу үйл ажиллагааны шалгуурыг тавьж болно. |

|                           |   |
|---------------------------|---|
| 18. Салбар:               | Аж үйлдвэрлэл   |
| Дэд салбар:               | Нэхий, арьс шир боловсруулах үйлдвэрлэл   |
| Хадгалах нөхцөлийн төрөл: | Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)  |
| Арга хэмжээ:              | Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоол болон Засгийн газрын 2013 оны 48 дугаар тогтоол                                      |
| Тайлбар:                  | Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллагаас тогтоосон газарт түүхий арьс, шир боловсруулах шаардлагатай. |